

Golomt Capital[®]
Delivering diversity

КРИПТО

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.03.11

Крипто зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын Ерөнхийлөгч асан Дональд Трамп "Крипто Стратегийн Нөөц" байгуулах тухай Ерөнхийлөгчийн зарлиг гаргав – BTC, ETH, XRP, SOL, ADA зэрэг криптовалютуудыг хамарна.
- Нэгэн крипто whale Трампын мэдэгдлийн өмнө BTC, ETH дээр 50х хөшүүрэгтэй BUY позиц авч, 7 сая ам.долларын ашиг олжээ
- DekaBank институцийн хөрөнгө оруулагчдад зориулсан крипто арилжаа, хадгалалтын үйлчилгээг эхлүүлэв.
- Citadel Securities крипто арилжааны зах зээлд нэвтрэхээр сонирхож байна.
- ARK Invest, Coinbase-ийн хувьцаанаас 8.7 сая ам.доллар худалдан авч, ARKB Bitcoin ETF-ээс ижил хэмжээний хувьцаа борлуулжээ.
- SEC, Coinbase-ийн эсрэг нэхэмжлэлээ буцаан татав.

АНУ-ын ерөнхийлөгч Donald Trump:



Биткойны нөөц байгуулах тухай зарлигт гарын үсэг зурлаа

Крипто мэдээ

АНУ биткойны нөөцтэй болохоо баталсан ч ханш нь унав

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп стратегийн биткойны нөөц байгуулах тухай зарлигт гарын үсэг зурлаа. Энэ нөөцийг холбооны засгийн газар нь эрүүгийн болон иргэний хэрэгт хураагдсан биткойноор бүрдүүлнэ гэж Цагаан ордны крипто зөвлөх Дэвид Сакс мэдэгдэв.

- АНУ-ын засгийн газар 200,000 биткойн эзэмшдэг гэж үзэж байна.
- Шинэ стратеги нь татвар төлөгчдөд криптогийн үнэ өсөлтөөс ашиг хүртэх боломж олгох аж.
- Трампын крипто дэмжлэг нь түүний гэр бүлийн крипто бизнест ашигтай байж магадгүй гэсэн асуудал дагуулж байна.

Bitcoin дахин сэргэх үү?

Bitcoin Dominance-ийн өндөр хувь нь хөрөнгө оруулагчид Биткойнд илүү итгэлтэй байгааг, харин бага хувь нь альткойнуудад (Биткойноос бусад криптовалюта) итгэлтэй байгааг харуулдаг. Одоогийн байдлаар **Bitcoin Dominance** ойролцоогоор **61.91%** байна. Иймээс ханш унасан гэсэн биткойнд илүү итгэлтэй байдал хэвээр байсаар байна.



БИТКОЙН - BTC



BTC үнэ 93,000-97,000 USD хооронд 2 долоо хоногийн турш арилжаалагдсан. Гэсэн ч ханш 90,000 USD-ээс доош маш хүчтэй унан 78,000 USD хүрсэн ч буцаад хүчтэй сэргэсэн ч удаан тогтсонгүй. Харин үүний дараа BTC нөөц байгуулах зарлигт Trump гарын үсэг зурсан боловч нэмж BTC худалдаж авахгүй, одоо байгаа нөөцөө ашиглана хэмээн мэдэгдсэн нь ханш унах шалтгаан болов. Чухал түвшнүүд 74,000 болон 66,000 байна. Энэ долоо хоногийн уналт үргэлжлэн 74,000 дээрээс тогтон sideways хөдөлгөөн явах магадлалтай.

Golomt Capital published on TradingView.com, Mar 11, 2025 10:54 UTC+8

Bitcoin / U.S. Dollar - 1D - COINBASE O78,548.18 H79,678.23 L76,555.00 C79,320.93 +776.22 (+0.99%) +776.22 (+0.99%)



ЭФИРИУМ - ETH



ETH үнэ биткойны хөдөлгөөнтэй төстэй явж байгаа ч 2021 оны дээд ханшаа хараахан эвдээгүй билээ. 2,150 USD түвшийн чухал бүс байсан боловч Crypto Summit болон биткойны нөөцтэй холбоотой мэдээгээр доош унасан. Харин зах зээл сэргэх хүртэл 1,520- 2,100 гэсэн ханшийн хооронд sideways хөдөлгөөн үүсгэх магадлалтай байна.

Golomt Capital published on TradingView.com, Mar 11, 2025 11:03 UTC+8

Ethereum / U.S. Dollar - 1D - BINANCE O1,866.75 H1,890.89 L1,756.86 C1,866.01 +0.30 (+0.02%) +0.30 (+0.02%)



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖУУД



ETF нэр	Товчлол	Зорилго
iShares Bitcoin Trust	IBIT	Биткойны үнийн гүйцэтгэлийг дагах
Fidelity Wise Origin Bitcoin Fund	FBTC	Биткойны үнийн гүйцэтгэлийг дагах
Grayscale Bitcoin Trust	GBTC	Биткойны үнийн гүйцэтгэлийг дагах
iShares Ethereum Trust	ETHA	Эфирийн үнийн гүйцэтгэлийг дагах
ARK 21Shares Active Bitcoin Ethereum Strategy ETF	ARKY	Биткойн болон Эфирийн фьючерс гэрээнүүдэд хөрөнгө оруулах
Bitwise 10 Crypto Index Fund	BITW	Тэргүүлэгч 10 криптовалютын үнийн гүйцэтгэлийг дагах
Amplify Transformational Data Sharing ETF	BLOK	Блокчэйн технологийг хөгжүүлж буй компаниудад хөрөнгө оруулах
Siren Nasdaq NexGen Economy ETF	BLCN	Блокчэйн технологийг ашиглаж буй компаниудын гүйцэтгэлийг дагах
First Trust Indxx Innovative Transaction & Process ETF	LEGR	Блокчэйн дэд бүтэц, технологид суурилсан компаниудад хөрөнгө оруулах

Disclaimer | Хариуцлагын мэдэгдэл

Энэхүү тайлан нь зөвхөн мэдээллийн зориулалттай бөгөөд хөрөнгө оруулалтын зөвлөгөө, санхүүгийн зөвлөмж биш юм. Энэхүү мэдээлэл нь зах зээлийн нөхцөл байдал, олон нийтийн эх сурвалж, найдвартай гэж үзсэн мэдээлэлд тулгуурласан боловч түүний үнэн зөв байдал, бүрэн бүтэн байдал, найдвартай байдлыг баталгаажуулах боломжгүй.

Криптовалют болон холбогдох санхүүгийн хэрэгслүүд нь өндөр эрсдэлтэй, үнэ нь зах зээлийн өөрчлөлт, зохицуулалтын өөрчлөлт, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, бусад олон хүчин зүйлээс хамаарч огцом савлагаанд орж болзошгүй. Өнгөрсөн гүйцэтгэл нь ирээдүйн үр дүнг баталгаажуулахгүй бөгөөд аливаа хөрөнгө оруулалт нь эрсдэл дагуулдаг.

Хөрөнгө оруулагчид аливаа хөрөнгө оруулалт хийхээс өмнө өөрийн санхүүгийн байдал, эрсдэл даах чадвар, хөрөнгө оруулалтын зорилгоо сайтар үнэлж, мэргэжлийн санхүүгийн зөвлөхтэй зөвлөлдөхийг зөвлөж байна. Энэхүү тайлангийн агуулгад үндэслэн гаргасан аливаа шийдвэрээс үүдэн гарах хохирол, алдагдлын хариуцлагыг манай байгууллага хүлээхгүй болно.